

БАТЛАВ.
БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Х.БАТЖАРГАЛ
2024.09.23

ATA12937 9116621 9024070582

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН
ХҮҮХДИЙН ХООЛНЫ ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАРДЛЫГ ЭЦЭГ ЭХ, АСРАН
ХАМГААЛАГЧ, ХАРГАЛЗАН ДЭМЖИГЧЭЭС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ (ХООЛ
ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ) СИСТЕМД ТАВИХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

| Бүлэг | № | Шаардлага | Зайлшгүй шаардлагатай | Зөвлөмжийн шинжтэй |
|----------------------------------|----|---|-----------------------|--------------------|
| Нийтлэг шаардлага | 1 | Систем нь веб, мобайл аппликейшн байна | + | |
| | 2 | Системд нэвтрэх эрхийн нууцлалтай ханддаг байх | + | |
| | 3 | Хэрэглэгчдэд нууц үг олгох, сэргээх боломжтой байх | + | |
| | 4 | Систем нь хэрэглэгчийн үйлдлүүдийн логийг хадгалдаг байх | + | |
| | 5 | Хэрэглэгчийн эрхийн зохицуулалттай байх | + | |
| | 6 | Хэрэглэгчийн интерфэйс нь Монгол хэл дээр байх | + | |
| | 7 | Пакет болон бусад гаднын халдлагаас хамгаалагдсан байх | + | |
| | 8 | Өгөгдлийн санг нөөцөлж хадгалдаг байх | | + |
| | 9 | Систем нь холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангаж ажилладаг байх | | + |
| Үндсэн үйл ажиллагааны шаардлага | 10 | Систем нь эрхлэгч, нягтлан бодогч, анги удирдсан багш, хоолны газар, асран хамгаалагч, бусад гэсэн эрхүүдтэй байх | + | |
| | 11 | Хэрэглэгч бүр өөр өөрийн эрхээр нэвтэрдэг байх | | + |
| | 12 | Хэрэглэгчийн тоонд хязгаарлалт тавихгүй | + | |
| | 13 | Эрхлэгч болон түүнтэй дүйцэхүйц албан тушаалтан системийн эрхүүдийг өгөх, цуцлах эрхүүдийг удирддаг байх | + | |
| | 14 | Эцэг эх, асран хамгаалагч өөрийнхөө мэдээллээр өөрөө системд бүртгүүлэх бөгөөд зөвхөн өөрийн хүүхдийн мэдээллийг харах үйл явц, | + | |

| | | | |
|----|--|---|--|
| | хамгаалалтыг системээр зохицуулсан байх | | |
| 15 | Эцэг эх, асран хамгаалагч өөрийн эрхээр нэвтрэн орж зөвхөн өөрийн хүүхдийн мэдээллийг хардаг байх | + | |
| 16 | Анги удирдсан багш ангийн хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчдын мэдээллийг харах, шаардлагагүй асран хамгаалагчийн эрхийг цуцалдаг байх | + | |
| 17 | Анги удирдсан багш ирц бүртгэхэд асран хамгаалагчид мэдэгдэл очдог байх | + | |
| 18 | Эцэг эх, асран хамгаалагч тухайн өдрийн ирцийг баталгаажуулдаг байх. Хэрвээ баталгаажуулаагүй тохиолдолд ирц нь дараа өдөр нь автоматаар баталгааждаг байх | + | |
| 19 | Баталгаажсан ирцийн төлөв дээр эцэг эх, асран хамгаалагч гомдол гаргах боломжгүй байх | + | |
| 20 | Хэрвээ ирцийн мэдээлэл буруу бол эцэг эх, асран хамгаалагч системээр дамжуулан гомдол гаргадаг байх | + | |
| 21 | Эцэг эх, асран хамгаалагчийн гаргасан гомдлын дагуу анги удирдсан багш ирцийн төлвийг өөрчилдөг байх | + | |
| 22 | Эцэг эх, асран хамгаалагч системээр дамжуулан чөлөөний хүсэлт гаргах, шаардлагатай тохиолдолд баримтыг хавсаргах боломжтой байх | + | |
| 23 | Анги удирдсан багш хүүхдийн чөлөөтэй, өвчтэй зэргийг систем дээр бүртгэх боломжтой байх. | + | |
| 24 | Тасалсан, өвчтэй, чөлөөтэй ирцтэй хүүхдүүдэд хоолны төлбөр бодогдохгүй. Зөвхөн ирсэн төлөвтэй сурагчдад хоолны төлбөр гарах | + | |
| 25 | Гал тогооны ажилчид тухайн өдрийн нийт ирцийн тоог харж хоол үйлдвэрлэх боломжтой байх | + | |
| 26 | Гал тогооны ажилчид хоолны мэдээллийг оруулдаг байх. Үүнд: хоолны нэр, зураг, орц найрлага, хэмжээ, шим тэжээлийн мэдээлэл | + | |
| 27 | Хоолны түүхий эдийг захиалах, хүлээж авах, гарцыг баталгаажуулах | + | |
| 28 | Эцэг эх, асран хамгаалагчид тухайн өдрийн хоол болон сарын хоолны цэсийг нэгдсэн байдлаар хардаг, сэтгэгдэл үлдээдэг байх | + | |

| | | | | |
|--|----|--|---|--|
| | 29 | Хоол үйлдвэрлэлийн тайланг /хоолны орц, гарц, тоо ширхэг, хоолны үлдэгдэл/ өдрөөр болон хүссэн хугацааны интервалаар цэцэрлэгийн эрхлэгч, хоолны газар болон нягтлан эрх бүхий хэрэглэгчид хардаг байх | + | |
| | 30 | Хоолны төлбөрийн нэхэмжлэхийг нягтлан сарын аль ч үед автоматаар үүсгэдэг байх | + | |
| | 31 | Аль бүлгийн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч төлбөрөө төлсөн, төлөөгүй гэсэн тайланг ангийн багш, нягтлан бодогч, цэцэрлэгийн эрхлэгч хардаг байх | + | |
| | 32 | Багш зөвхөн өөрийн ангийн хүүхдийн төлбөрийн мэдээллийг хардаг байх | + | |
| | 33 | Эцэг эх, асран хамгаалагч зөвхөн өөрийн хүүхдийн хоолны төлбөрийн нэхэмжлэхийг хардаг байх | + | |
| | 34 | Эцэг эх, асран хамгаалагч мөн өөрийн хүүхдийн идсэн хоолны түүх болон өмнө төлсөн төлбөрийн мэдээллүүдийг хардаг байх, маягт-2 дагуу мэдээллийг цахим эсхүл бусад байдлаар баталгаажуулдаг байх | + | |
| | 35 | Төлбөр амжилттай төлөгдсөн мэдэгдэл ирдэг байх | + | |
| Төлбөр тооцооны шаардлага | 36 | Эцэг эх, асран хамгаалагч хоолны төлбөрийг системээр дамжуулан цахимаар шууд төлөх боломжтой байх | + | |
| | 37 | Төрийн сангийн дансанд цахимаар төлсөн болон дансанд бэлэн мөнгөөр төлсөн төлбөрүүдийг бүртгэдэг байх | + | |
| | 38 | Зорилтот бүлэг (Нийгмийн халамжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1-20.2.5-д заасан хүүхэд, уртасгасан цагийн зохицуулалттай 24 цагийн цэцэрлэгийн бүлэг болон цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхэд, 3 болон түүнээс дээш хүүхэд цэцэрлэгт хамрагдаж байгаа тохиолдолд 3 дахь хүүхдээс төр даах) хүүхдийн мэдээллийг ESIS(боловсролын удирдлагын мэдээллийн систем)-ээс авч тухайн хүүхдүүд дээр хоолны төлбөр гардаггүй байх | + | |
| Бусад системийн холболтын шаардлага | 40 | ESIS системтэй холбогдож цэцэрлэгийн багш ажилтан, бүлэг, сурагчдын мэдээлэл, хоолны нэр төрлийн мэдээллийг авдаг байх | + | |
| | 41 | Хоолны тайлан ESIS систем рүү | + | |

| | | | | |
|------------------|----|---|---|---|
| | | автоматаар дамжуулдаг байх, мөн төлбөр тооцооны системүүдтэй холбогдож төлбөрийг цахимаар төлөх боломжтой байх | | |
| | 42 | И-баримтын системд холбогдох, төлбөр төлсөн эцэг эх, асран хамгаалагчдад төлбөрийн и-баримт олгодог байх | | + |
| | 43 | Бусад системтэй холбогдож болно. Үүнд: цахим гэрээ, ДАН систем гэх мэт... | | + |
| Тайлагнах | 44 | ESIS систем рүү өдрийн ирцийн мэдээллийг бодит цагийн горимд илгээдэг байх | + | |
| | 45 | Төрийн байгууллагаас батлагдсан маягт (Боловсролын сайдын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/84 дүгээр тушаал)-ын дагуу төвлөрүүлсэн төлбөрийн тайлан системээс шууд гардаг байх | + | |
| | 46 | Цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч, багш болон эцэг эхчүүд системээр хүүхдийн идсэн хоолны тайлан болон төлбөр төлсөн мэдээллийг нэгдсэн байдлаар хардаг байх | + | |
| | 47 | Тайлангуудыг экспорт хийдэг байх | + | |